

Жаргалант тосгоны хүн эмнэлэг

Тус эмнэлэг нь анх 1972 онд Гачууртын САА-гаас Аюушийн амны ферм тасрахад бага эмчийн салбар нэртэйгээр 50 ортой анх байгуулагдаж, 1975 онд АДХГЗ-ны 36 дугаар тогтоол, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 22 тоот тушаалаар 1975 оны 06 дугаар сарын 01-нд 15 ортой их эмчийн салбар болон өргөжсөн байна.

Эмнэлэг нь тэр үеэс өнөөг хүртэл улам өргөжсөн орчин үеийн шинэ барилгатай, аппарат тоног төхөөрөмжтэй эмнэлгийн боловсон хүчнээр хангагдаж тус хороо тосгоны 1300 гаруй ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг 35 жил үзүүлж ирлээ.

Эмнэлгийг анх бага эмч Луузан, даргаар нь Бааст, Мандал, Г.Дэмбэрэл, Мягмарсүрэн, зэрэг эмч удирдаж, 1986-1995 онуудад Д.Жүгдэр эмч, 1995-2005 онд Анагаах ухааны доктор Б.Равдан эмч, 2005 оноос одоог хүртэл Н.Сүрэнчулуун эмч удирдан ажиллаж байна.

Эмнэлэг нь өнөөг хүртэл улам өргөжин орчин үеийн шинэ барилгатай, аппарат тоног төхөөрөмжтэй, эмнэлгийн боловсон хүчнээр хангагдаж тус хороо тосгоны 1300 гаруй өрхийн 5300 гаруй ард иргэдэд бие даан эмнэлгийн анхан шатны болон иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг зохион байгуулан ирсэн. Үйлчлэх хүрээний радиус 2-50 км, сард 2 удаа хөдөө багаар тойрч 0-5 насны хүүхдүүд, жирэмсэн эхчүүд өндөр нас-тангуудаа эргэж хяналтын үзлэг хийж хэвшсэн.

Эмнэлгийн чанарын үзүүлэлтүүд жил ирэх тусам чанаржих эх нярайн эндэгдэлгүй, дархлаажуулалтыг 99-100% хийж, жирэмсний эрт үеийн хяналтыг 75-80%-д хүргэж ажилласнаар сүүлийн 3 жил тосгоны эмнэлгүүдээ тэргүүлж ажиллаж байна.

Эмнэлгийн барилгын эхний хэсгийг 1995 онд хотын хөрөнгө оруулалтаар 25 сая төгрөгөөр, хоёрдох хэсгийг 26 сая төгрөгөөр, 2000 онд гурав дахь хэсгийг Японы өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд 81000 ам долларын өртөгтэйгөөр 2004 онд тус тус бариулж ашиглалтад оруулсан нь иргэд хөдөлмөрчдийн талархлыг зүй ёсоор хүлээж, тэднийг тав тухтай орчинд сэтгэл ханамжтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна.

УИХ-ын гишүүн байсан Баасанжав төмөр замын 361-р гарамд хэсгийн эмнэлгийн барилгыг 2004 онд бариулж өгсөн нь эмнэлэг нь үйлчилгээг хөдөлмөрчдөд ойртуулах таатай нөхцөл боломжоор хангаж өгсөн.

Эмнэлэг нь яаралтай тусламжийг цаг алдалгүй хүргэх фургон машиныг 2006 онд УИХ-ын гишүүн Тэрбишдагвын дэмжлэгтэйгээр туслалцаатайгаар ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар авч ашиглаж байгаа ба 2002 оны Сузика мотоцикл, 1995 оны УАЗ-469 машинтай ажиллаж байна боловсон хүчнүүд бүгд эмчлэх болон сувилах эрхийн зөвшөөрөлтэй ажиллаж байна.

Одоо эмнэлэг нь 30 гаруй эмч, ажилчидтай, жилдээ 156 сая төгрөгийн төсөвтэйг ээр үйл ажиллагаа явуулж байна. Тус эмнэлэг нь их эмч 5, бага эмч 3, сувилагч 9, асрагч 6, нярав, нябо, галч, тогооч тус бүр 1, жолооч 2 ажиллаж байна.

Дээрх эмч ажилчдын дотроос анагаах ухааны доктор 1, Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан 5, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын тэргүүний ажилтан 2, Эрүүл мэндийн яамны хүндэт жуухаар 5, Улаан загалмайн Тэргүүний ажилтан тэмдгээр 1,

Тэргүүний сувилагч алтан медалиар 2, Аврахуйн үйлстэн алтан медалиар 2, Монголын залуучуудын холбооны Шилдэг залуу алтан медалиар 1, Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч медалиар 1 тус тус шагнагдан хамт олныгоо хошуучлан ажиллаж байна.

Тус эмнэлэг нь 2008 оноос "Ёс зүйтэй орчинд ёс суртахуунтай үйлчилгээ үзүүлье" уриан дор үйлчлүүлэгчдийг тосч үйлчлэн үдэж гаргах үйлчилгээг нэвтрүүлэн хүн нэг бүртэй тулж ажиллан сар бүр" Нээлттэй хаалганы өдөр"-ийг зохион байгуулж байна.

Эмнэлэг нь эмнэлгийн үйлчилгээг ард иргэдэд улам ойртуулан тухайн цаг үе нөхцөлд тохирсон, үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангасан нарийн мэргэжлийн тусламжийг чанартай үзүүлэх хэтийн зорилготой.

- Эмчилгээ оношлог оог сайжруулан үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, байгууллагын үйлчилгээний чанар бүтээмжийг нэмэгдүүлэх

- Хүний нөөцийн менежментийг сайжруулан байгууллага чадварлаг хөврөх чадвар сайтай мэргэжилтнээр хангах, хүн дээрээ тулгуурлан байгууллагаа хөгжүүлэх,

- Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төрөө баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлж ард иргэдийн эрүүл мэндийн боловсролын төвшинг дээшлүүлэх

- Эмнэлгийн тоног төхөөрөмж, эд хогшлын хангалтыг төлөвлөгөөтэйг ээр чанаржуулан тухайн үеийн шаардлагын төвшинд хүргэх

- Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөл үзүүлэн урам зоригийг сэргээн ажилдаа хандах хандлагыг өөрчлөх дэвшүүлсэн зорилтуудтай ажилладаг.